



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эцэг эхчүүдээс хандивласан нийт 11,000,000.00 (арван нэгэн сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэг (Ж.Нарандулам)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэг (Ж.Нарандулам)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын даргын 2025 оны 06... дугаар сарын 04 өдрийн А/У... дугаар тушаалын хавсралт

Бүртгэх эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 66 дугаар цэцэрлэг

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Принтер	Epson L3269	3 үйлдэлт	2025	сайн	ш	1	500,000.00	500,000.00		
2	Зурагт	Samsung	45 инч	2025	сайн	ш	1	650,000.00	650,000.00		
3	Зурагт	TCL	55 инч	2025	сайн	ш	1	800,000.00	800,000.00		
4	Ус цэвэршүүлэгч	Skyworth	420W	2025	сайн	ш	1	250,000.00	250,000.00		
5	Принтер	Epson L3256	3 үйлдэлт	2025	сайн	ш	1	500,000.00	500,000.00		
Машин, тоног төхөөрөмжийн дүн											
6	Дүрслэх урлагийн тавиур	Монгол	ДСП, ягаан, 3 хэсэгтэй	2025	сайн	ш	1	400,000.00	400,000.00		
7	Дрож	хятад	шаргал, цэцгэн хээтэй	2025	сайн	м	10	150,000.00	1,500,000.00		
8	Дүрслэх урлагийн тавиур	Монгол	ДСП, ягаан, цэнхэр	2025	сайн	ш	2	250,000.00	500,000.00		
9	Дрож	хятад	амьтдын зурагтай	2025	сайн	м	8	220,000.00	1,760,000.00		
10	Тоглоомын тавиур	Монгол	ДСП, ягаан, 4 хэсэгтэй	2025	сайн	ш	1	400,000.00	400,000.00		
11	Дрож	хятад	саарал хээтэй	2025	сайн	м	7	220,000.00	1,540,000.00		
12	Дрож	хятад	саарал цэнхэр, шар дүрстэй	2025	сайн	м	10	220,000.00	2,200,000.00		
Тавилга, эд хогшгийн дүн											
Бүртгэх хөрөнгийн нийт дүн											
									8,300,000.00		
									11,000,000.00		

Эцэг эхчүүд Хандив